

ОЛОН УЛСЫН РАДИО НЭВТРҮҮЛГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ЗАРИМ АСУУДАЛ

Г.Мэндхүү*, Дэгжирэх**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үгс: радио өргөн нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, суртал ухуулга, соёлын солилцоо, зөөлөн хүч, интернэт

Радио долгион ашиглан үндэсний хил хязгаарыг даван туулж, өргөн уудам орон зайд мэдээлэл дамжуулах болсон цаг үе нь ХХ зууны хориод оноос эхэлдэг. Тухайн үеэс “олон улсын радио өргөн нэвтрүүлэг” гэдэг нэр томъёог мэргэжлийн ном зохиолд төдийгүй сэтгүүл зүйн практикт өргөн хэрэглэдэг болов. Үүний зэрэгцээ “гадаад нэвтрүүлэг”, “гадаад оронд зориулсан нэвтрүүлэг” зэрэг холбоо үгийг өргөн хэрэглэдэг болжээ (Н.С.Барабаш, 2000). Гадаадын сонсогчдод зориулсан өргөн нэвтрүүлэг нь тухайн улсын ОНМХ-ийн системийн чухал салшгүй нэг хэсэг болдгоос гадна дипломат харилцаа, соёлын харилцаа, олон улсын мэдээлэл солилцох сүлжээний гол суваг болж чаддаг. Туршлагаас үзэхэд, олон улсын радио нэвтрүүлэг нь дэлхийн ард түмний хооронд харилцан ойлголцол, найрсаг харилцаа, харилцан итгэлцлийг бий болгодог. Олон улсын харилцаанд ээдрээтэй асуудал үүсэхэд гадаадын

сонсогчдод зориулсан тусгай нэвтрүүлгийн тусламжтайгаар нөхцөл байдлыг зөөлрүүлэх оролдлого ч хийгдэж байсан жишээ байдаг. Заримдаа гадаадын сонсогчдод зориулсан тусгай нэвтрүүлгийн үеэр хэн нэгэн хүний хэлсэн үг, сэтгүүлчийн сонгож авсан баримт нь өөр орны сонсогчдын эгдүүцлийг төрүүлж хоёр улсын хооронд үл ойлголцох байдал, аль нэгэн бүс нутагт тогтворгүй байдал үүсгэж байсан түүх олныг дурдаж болно.

Гадаадын сонсогчдод зориулан нэвтрүүлэг бэлтгэх нь өөрийн гэсэн онцлогтой. Харь улсын сонсогчдод зориулсан нэвтрүүлэг нь гадаад хэлээр, эсвэл нэвтрүүлэг бэлтгэж байгаа улсын төрийн албан ёсны хэлээр бэлтгэгдсэн байдаг. Гадаадын сонсогчдод зориулсан радио нэвтрүүлэг нь тухай улс орныг гадаадад сурталчлах чиглэлийн хүрээнд явагддаг бөгөөд түүх, соёл урлаг, аялал жуулчлал, тухайн үндэстний дахин давтагдашгүй амьдралын өвөрмөц хэв маяг, үндэстний брэнд бараа бүтээгдэхүүн, спорт, олон улсын уралдаан тэмцээний тухай сэдэв зонхилдог. Улс үндэстний соёл гэдэг бол тухайн улсын имиж, өөртөө жуулчдыг татах

нэгэн арга, соён гэгээрүүлэх арга зам юм. Аливаа улс гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ олон төрлийн арга ашигладгийн нэг нь “зөөлөн хүч” (soft power) бөгөөд үүнийг хэрэгжүүлэх гол суваг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, урлаг соёлын бүтээл болдог.

Соёл урлагаар дамжуулан олон улсын түвшинд улс орон, ард иргэд, улс төр, эдийн засгийн бодлогынхоо тухай эерэг дүр төрхийг бүрдүүлэх, түнш орнуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлэх, болзошгүй зөрчил мөргөлдөөнөөс зайлсхийх зэргээр тодорхойлогдох бөгөөд урлаг, олон улсын үзэсгэлэн, солилцооны хөтөлбөр зэргээр дамжин зөөлөн хүчний бодлого илэрдэг. Олон улсын асуудлын талаар мэдээлэхдээ үндэсний эрх ашгаа хамгаалах зарчмыг эрхэмлэдэг байна. Гадаадын хүлээн авагчдад зориулсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн орны ёс заншил, түүх, соёлыг хэт сайшааж бусдыг үгүйсгэвэл үндэстэн дамнасан маргаан гарах, хоёр улсын харилцаанд сэв суух магадлалтай учир дээрх сэдвээр мэдээлэхдээ танин мэдүүлэх талаас нь хандах нь нийтлэг. Зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлэн мэдээллийн урсгал бий болгох үйл ажиллагааны зорилго нь улс орон бүр өөрийнхөө нэр хүндийг олон улсын тавцанд дээшлүүлэх, соёлоор дамжуулан геополитикийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байдаг. Цаг үеийн нөхцөл байдал, эдийн засаг, улс төр ба нийгмийн өөрчлөлт, технологийн хөгжлөөс хамаарч олон улсын радио өргөн нэвтрүүлгийн сэдэв, мэдээллийн агуулга, мэдээлэл түгээж байгаа арга зүй хувьсан өөрчлөгддөг. Дэлхийн улс орнуудын харилцаа, хамтын ажиллагааны түвшин олон улсын мэдээлэл солилцох үйл явцад шийдвэрлэх

чухал нөлөө үзүүлдэг юм. Тухайлбал, ХХ зууны дунд үед олон улсын радио нэвтрүүлэгт социалист ба капиталист орнуудын өрсөлдөөн гол сэдэв байв. Социалист орнууд өөрсдийн хөгжлийн замыг зөвтгөсөн суртал ухуулга явуулж байсан бол капиталист орнууд хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголтыг олон улсын радио нэвтрүүлгийн гол номлол, үзэл баримтлал болгож байв. ХХ зууны эцэст олон улсын радио нэвтрүүлгийн агуулга, сэдэв нь өөрчлөгдөж олон улсын алан хядлага, шашны хэт даврагсад, салан тусгаарлагчид, хүрээлэн байгаа орчны асуудал, байгаль хамгаалал зэрэг болжээ. Олон улсын харилцаанд гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан гадаадын сонсогчдод зориулсан нэвтрүүлгийнхээ хэлний сонголтыг ч өөрчлөх байдал ажиглагддаг. Жишээ нь, 2003 оноос “Америкийн дуу хоолой” радио станц болгар, чех, эстони, унгар, латви, литва, польш, словени, румын хэлээр нэвтрүүлгээ зогсоосон бол, 2007 оноос Украин, Казахстан, Туркмен улсын сонсогчдод зориулан явуулдаг сувгаа хаажээ. Мөн 2008 оноос “Америкийн дуу хоолой” радио станц хятад хэлээр агаарын долгионоор нэвтрүүлэг дамжуулахаа зогсоож, зөвхөн интернэт орчинд мэдээллээ түгээх болсон байна (Н.А., 2013). Энэ бүх өөрчлөлт нь цаг үеийн шинжтэй бөгөөд шаардлагатай бол ийм радио сувгаа дахин нээх бүрэн бололцоотой ажээ.

Гадаадын сонсогчдод зориулан радио нэвтрүүлэг явуулснаар хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдээ мэдээллээр хангах, гадаадын сонсогчдын үзэл бодлыг өөрчлөх зорилготой. Сонсогч олон улсын радиогийн нэвтрүүлгийг хүлээн

авч сонсдог хэдэн шалтгаан бий. Юуны түрүүнд өөрийн эх орных нь ХМХ-ээр огт хөндөхгүй байгаа сэдвийг олон улсын радиогоор нэвтрүүлдэг. Мөн дэлхий дахинд болж байгаа үйл явдлын тухай янз бүрийн байр суурийг илэрхийлсэн мэдээллийг сонсогч сонирхож байдаг. Эцэст нь тухайн нэвтрүүлгийг бэлтгэн цацаж байгаа улсын иргэдийн аж амьдрал, соёл, урлаг, түүхийн талаар мэдэх гэсэн сонсогчийн эрмэлзэл байдаг.

Өнөөдрийн байдлаар бараг дэлхийн бүх улс гадаадын хүлээн авагчдад чиглэсэн радио, теле нэвтрүүлэг бэлтгэж байна. Олон улсын радио өргөн нэвтрүүлэг бэлтгэн түгээж байгаа үзүүлэлтээрээ АНУ, ОХУ, БНХАУ, ХБНГУ, Их Британи эхний тавд бичигдэж байгаа бол Египет, Иран, Энэтхэг, Япон, Нидерланд, Израиль зэрэг улсууд бусад орны сонсогчдод зориулсан радио өргөн нэвтрүүлэг бэлтгэн явуулахад их ач холбогдол өгч, нэвтрүүлгийн цаг, гадаад хэлний сонголтыг нэмэгдүүлж байна. Олон улсын хэмжээний радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг төрөөс санхүүжүүлдэг. АНУ-ын “Америкийн дуу хоолой”, ХБНГУ-ын “Дойче велле”, ОХУ-ын “Спутник” (хуучин нэрээр “Оросын дуу хоолой”), БНХАУ-ын “Хятадын олон улсын радио” зэрэг нь татвар төлөгчдийн мөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг. Зарим улс оронд олон нийтийн, төрийн бус, шашны байгууллагууд олон улсын радио нэвтрүүлгийг санхүүжүүлэх тохиолдол бий.

Гадаадын сонсогчдод зориулан тусгай радио нэвтрүүлэг явуулах болсон анхны улсын тоонд Герман, Франц, Их Британи улс ордог. 1926 оноос “Парисын радио”, “Германы

радио” урт долгионоор, 1927 оноос “BBC” радио богино долгионоор Ази, Африкийн орнуудын сонсогчдод нэвтрүүлэг дамжуулах болжээ. Үүний дараа 1928 оноос Польш, 1929 оноос Оросын төв радио нь гадаадын сонсогчдод зориулан нэвтрүүлэг бэлтгэх редакц байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлж байжээ. XX зууны 30-аад оноос олон улсын радио нэвтрүүлэг нь суртал ухуулга хийхэд гол анхаарлаа хандуулав. Герман, АНУ, ЗХУ, Япон, Итали, Их Британи улсын радио станцууд радио өргөн нэвтрүүлгийг шууд суртал ухуулгын хэрэгсэл болгож улс төрийн зорилгоор ил тод ашиглаж болжээ. Дэлхийн II дайны он жилүүдэд сэргэлдэгч талын цэргүүдийн сэтгэл зүйд нөлөөлөх зорилгоор хуурамч мэдээ дамжуулж байв. Жишээлбэл, 1929 онд Германы засгийн газрын шийдвэрээр хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа германчуудад зориулан нэвтрүүлэг түгээх зорилгоор “Deutsche Welle” радиог байгуулагдаж, улмаар дэлхийн II дайны үед Кенигсбергээс Польш улс руу, Гамбург, Бремен хотоос Их Британи руу, Штутгарт, Франкфурт хотоос Франц руу тусгай нэвтрүүлэг дамжуулах болжээ. 1933 оноос Хойд Америкт амьдарч байгаа германчуудад зориулан нэвтрүүлэг бэлтгэх редакц нээж байсан бол 1939 оноос Африк, Өмнөд Америк, Зүүн Ази ба Арабын орнуудад зориулан суртал ухуулгын нэвтрүүлэг хийж байлаа. Дайны дараа “Deutsche Welle” гадаадын сонсогчдод зориулсан нэвтрүүлгээ зогсоосон боловч 1953 оноос дахин сэргээжээ. 1960-1970-аад онд “Deutsche Welle” радиогийн төв студи Кельн хотод байрлаж байсан бөгөөд 7 хоногт 100 гаруй цагийн нэвтрүүлгийг 30 хэлээр дамжуулж

байв. Харин өнөөдөр тус радио 39 хэлээр хоногт 100 цагийн нэвтрүүлэг явуулж байна. Тэгвэл Их Британи улсын BBC олон улсын радио нэвтрүүлгийн төлөвшилд их нөлөөлсөн бөгөөд дахин дамжуулах станцаа Их Британийн арлуудаас гадна Австрали, Канад, Шинэ Зеланд, Өмнөд ба зүүн Африк, Энэтхэг, Сингапур, Сянганд байгуулж байв. Дэлхийн II дайны он жилүүдэд BBC нь 45 хэлээр радио нэвтрүүлэг явуулж байсан туршлагатай. АНУ гадаадын сонсогчдод зориулсан радио өргөн нэвтрүүлгээ 1930-аад оноос туршилтын байдлаар эхэлж байв. 1942 онд АНУ-ын NBC, CBS радио станцууд Өмнөд Америкийн сонсогчдод зориулан испани, португаль хэлээр 7 хоногт 300 цагийн нэвтрүүлэг дамжуулж байлаа. 1950 онд гэхэд АНУ-ын радио станцууд гадаадын сонсогчдод зориулан бэлтгэдэг нэвтрүүлгийн цаг өдөрт 497 байсан бол 1972 оны эцэс гэхэд хоногт 2001 цагийн нэвтрүүлэг дамжуулж байлаа. Харин одоо АНУ-аас гадаадын сонсогчдод зориулан бэлтгэж байгаа нэвтрүүлгийн нийт хугацаа хоногт 4000 цаг болжээ.

1929 онд ЗХУ-ын нийслэлд төв студи нь байрладаг “Москвагийн радио” гадаадын сонсогчдод зориулсан анхны тусгай нэвтрүүлгээ герман хэлээр дамжуулжээ. Дэлхийн II дайны өмнөхөн ЗХУ-ын радио 13 хэлээр нэвтрүүлэг явуулж байсан бол дайны он жилүүдэд 21 хэлээр хоногт 21 цагийн нэвтрүүлэг бэлтгэх болсон. 1964 оноос “Москвагийн радио” монгол хэлээр тусгай нэвтрүүлэг бэлтгэж эхэлсэн бөгөөд Монголын радиогоос нэвтрүүлэгч нарыг урилгаар ажиллуулж байлаа. 1993 онд гадаадын 44 хэлээр нэвтрүүлэг дамжуулж байсан тус радиог ОХУ-ын

Ерөнхийлөгч Б.Н.Ельцины зарлигаар “Оросын дуу хоолой” хэмээн нэрлэжээ. Харин 2014 онд тус радиог татан буулгаж, бааз суурин дээр нь “Спутник” олон улсын радиог байгуулжээ. Тухайн үед монгол хэлээр нэвтрүүлэг явуулдаг редакц татан буугдсан байна.

Олон улсын радио нэвтрүүлгийн салбарт Монгол Улс өөрийн гэсэн орон зайг эзэлж, өнөөг хүртэл тасралтгүй 58 жил гадаадын сонсогчдод зориулсан тусгай нэвтрүүлэг бэлтгэж байна. 1964 оны 6 дугаар сарын 29-нд “Гадаадын сонсогчдод зориулан монгол хэлээр тусгай нэвтрүүлэг явуулж эхлэх тухай” Мэдээлэл, радиогийн улсын хорооны даргын 104 дугаар тушаал гарч, “Улаанбаатараас ярьж байна” гэдэг нэвтрүүлгийг долоо хоногийн пүрэв, ням гаригт 21 цагаас 30 минутын хугацаатай явуулж байхаар болжээ. Уг нэвтрүүлэг Хөххотын чиглэлд монгол хэлээр, Бээжингийн чиглэлээр хятад хэлээр, Өрөмчийн чиглэлд казах хэлээр тус тус цацагдаж байв. Улмаар гадаадын сонсогчдод зориулсан тусгай нэвтрүүлэг хариуцдаг хэлтсийг “Монголын дуу хоолой” радио станц хэмээн нэрлэхээр шийдвэрлэжээ. Монгол орныг гадаад улс орнуудад сурталчлах шаардлагын дагуу 60-аад онд радиогийн гадаад хэлээр явуулах нэвтрүүлгийн чанарыг сайжруулах, тоо хэмжээг өсгөх талаар удаа дараа чухал арга хэмжээ авсан (Л.Норовсүрэн & Н.Ариунзаяа, 2010). “Монголын дуу хоолой” радио станц 1968 оноос үйл ажиллагаагаа өргөжүүлж, 7 хоногт хятад хэлний нэвтрүүлэг 4 удаа явуулдаг байсныг өдөр бүр, монгол хэлний нэвтрүүлэг 4 удаа байсныг 6 удаа, казах хэлнийх 2 удаа байсныг 6 удаа, англи хэлнийх Ази, Африкийн хоёр

чиглэлээр 8 удаа байсныг 12 удаа болгон тус тус нэмжээ. Энэ үед гадаад хэлний нэг нэвтрүүлгийн хугацаа 30 минут байсан юм. Уг тогтоолоор бас франц хэлний нэвтрүүлгийг 7 хоногт 4 удаа шинээр явуулдаг болсон юм. Цаг хугацааны явцад франц, казах хэлээр дамжуулдаг нэвтрүүлгийн редакция татан буулгасан бөгөөд 2022 оны байдлаар англи, орос, хятад, япон хэлээр, мөн монгол хэл мэддэг гадаадын сонсогчдод зориулан монгол хэлээр тусгай нэвтрүүлэг явуулж байна. “Монголын дуу хоолой” радио станцын нэвтрүүлгийн сэдэв, агуулга нь бүхэлдээ монгол соёл, ахуй, зан заншлыг гадаадын сонсогчдод таниулахад чиглэсэн байдаг. “Монгол дуу хоолой” радио станц нь цаг үеийн мэдээ, сурвалжилга бэлтгэдэг бөгөөд нэвтрүүлгийн сүлжээнд нь “Шуудангийн хайрцаг”, “Монголын түүх”, “Монголд үйлдвэрлэв”, “Монгол дуу хөгжим” нэвтрүүлэг гол байр эзэлдэг.

Олон улсын радио өргөн нэвтрүүлгийн салбарт гол тоглогч нь БНХАУ болжээ. “Хятадын олон улсын радио” 1941 оны 12 дугаар сарын 3-нд байгуулагдаж япон хэлээр 15 минутын радио нэвтрүүлэг дамжуулж байжээ. Харин одоо 43 гадаад хэл, мөн хятад хэлний 4 аялгаар хоногт нийтдээ 211 цагийн нэвтрүүлэг дамжуулдаг. 1987 оноос “Хятадын олон улсын радио” нь Их Британи, Франц, Швейцарь, ОХУ, Испани, Канад, Мали, Бразил, Куба зэрэг улсын засгийн газартай харил-

цан тохиролцож хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Үүний үр дүнд “Хятадын олон улсын радио” нь нэвтрүүлгээ эдгээр бүс нутгуудад дахин дамжуулах боломжтой болжээ. Мөн тухайн бүс нутагт шинээр радио станц байгуулах, орон нутгийн радио станцын долгион ашиглан нэвтрүүлэг дамжуулдаг. Тус радио 1964 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс монгол хэлээр нэвтрүүлгээ цацаж эхэлжээ. 1998 оны эцсээр интернэтийн сүлжээнд монгол хувилбартай вэб-

сайтаа нээсэн. “Хятадын олон улсын радио” нь монгол хэлний нэвтрүүлгээ уламжлалт богино долгионоос гадна FM, интернэт сүлжээний хэлбэрээр цацагддаг. БНХАУ-ын “Хятадын олон улсын радио”-оос гадна Монгол Улсын сонсогчдод зориулан нэвтрүүлэг дамжуулдаг өөр нэг радио станц бий. Энэ бол Өвөр



Олон улсын радио өргөн нэвтрүүлгийн салбарт гол тоглогч нь БНХАУ болжээ. “Хятадын олон улсын радио” 1941 оны 12 дугаар сарын 3-нд байгуулагдаж япон хэлээр 15 минутын радио нэвтрүүлэг дамжуулж байжээ. Харин одоо 43 гадаад хэл, мөн хятад хэлний 4 аялгаар хоногт нийтдээ 211 цагийн нэвтрүүлэг дамжуулдаг



Монголын Өөртөө засах орны “Радио, Телевиз Хороо”-ны бүрэлдэхүүнд байдаг “Талын дуу хоолой” радио станц юм. Тус радио станц 2013 оны 3 дугаар сарын 1-нд байгуулагдаж монгол хэлний төв халх аялгаар анхны нэвтрүүлгээ дамжуулжээ. Энэ радио нь БНХАУ-ын гадаад бодлого, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын тухай мэдээллийг Монгол Улсын сонсогчдод хүргэсээр иржээ. “Талын дуу хоолой” радио станц нь Монгол Улсын “Билэгсанаа” компанийн дэргэдэх Монгол Туургатны “Шинэ долгион” FM-107,5 радио станцын долгионоор

хоногт 8 цагийн нэвтрүүлэг дамжуулдаг. “Шинэ долгион” FM-107,5 нь 1998 оны 5 дугаар сарын 15-нд байгуулагдсан Монгол Улсын анхны арилжааны радио станц юм. ӨМӨЗО-ы “Талын дуу хоолой радио станц” байгуулагдахаас хоёр жилийн өмнө 2011 онд ӨМӨЗО-ы Засгийн ордны Хэвлэл мэдээллийн албаны дарга Бай Юйган Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод ажлын айлчлал хийх үедээ радио өргөн нэвтрүүлгийн салбарт хамтран ажиллах тухай сэдвийг хөнджээ. Үүний үр дүнд 2013 оноос Монгол Улсын “Шинэ долгион” FM-107,5 радио, ӨМӨЗО-ы “Радио, Телевиз Хороо” хамтарч ажиллах гэрээг үзэглэсэн юм. Гэрээний дагуу “Шинэ долгион” FM-107,5 радиогоор “Талын дуу хоолой” радиогийн бэлтгэдэг “Аз жаргалын хөтөч”, “Соёлын алтан тулга”, “Тэнгэрлэг эгшиг”, “Ардын урлаг аман билэг”, “Үзэсгэлэнт сайхан нутаг ус”, “Солонго” зэрэг нэвтрүүлгийг Өвөр Монголоос шууд хүлээж авч цацаж байна. “Талын дуу хоолой” радио станц нь Улаанбаатар хотод өөрийн студийг байгуулсан бөгөөд “Сэтгэлийг анагаах аялгуу”, “Яруу үгсийн чуулган”, “Нутаг нутгийн аялгуу”, “Өврийн дэвтэр”, “Уран уншлагын цаг”, “Үлгэрийн цаг”, “Байгаль эхийн авиа”, “Эрүүл амьдрахуй, зөв хооллоё”, “Энэ цагийн дуулал”, “Дээжис”, “Мэндийн хадаг” зэрэг нэвтрүүлгийг бэлтгэж “Шинэ долгион” FM-107,5 радиогоор нэвтрүүлдэг. Эдгээр нэвтрүүлэг нь хөрш зэргэлдээ орших ах дүү орны ард түмний аж байдал, зан заншил, өв соёл, хөгжил цэцэглэлтийн талаар хангалттай сайн мэдээллийг өгч хоёр орны ард түмний харилцан бие биеэ ойлгох, найрамдлын харилцаагаа бэхжүүлэх, бүх талын соёлын солилцооны гүүр болоход нэн

тустай, ач холбогдолтой юм. Хоёр радио хамтарч ажилласан 9 жилийн хугацаанд жил бүр тогтмол сонсогчдын уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, тухайн жилийнхээ ажлыг дүгнэж, цаашдын радиогийн хөтөлбөртөө ямар агуулга хэлбэрийг оруулж баяжуулах, сонсогчдын эрэлт хэрэгцээг хангасан сонирхолтой нэвтрүүлэг бэлтгэх талаар ажил хэрэгч хэлэлцүүлэг зохион байгуулдаг байна.

“Нэг бүс нэг зам” төслийн салшгүй хэсэг болсон хоёр орны радиогийн хамтын ажлын замнал нь цаашдаа ч өргөжин дэвжих нь дамжиггүй бөгөөд хоёр улсын ард түмний хоорондын соёлын солилцооны томоохон гүүр хэвээр байх болно хэмээн “Талын дуу хоолой” радио станцын хамт олон дүгнэдэг байна. БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпин “Улсынхаа үндэсний имижийг бүрдүүлэхэд бид онцгой анхаарч байна. Өөр хоорондоо дасан зохицсон олон янзын соёл, угсаатны бүлэгтэй, эртний баялаг түүхтэй, иргэншсэн улсын дүрийг бий болгоход чиглэсэн. Бид хүн төрөлхтний хөгжилд хувь нэмэр оруулж, олон улсын тавцанд шударга ёсыг дэмжиж бүх нийтийг хөгжилд хүргэх хариуцлагатай их гүрний имижийг баримтлах болно” (Xinhua, 2013) хэмээн мэдэгдэж байсан юм. Гадаадын улс орнуудын иргэдэд чиглэсэн мэдээллийн урсгал үүсгэх, олон улсын харилцааны асуудлаар Хятадын байр суурийг дэлхий дахинд сонордуулах улс орныхоо имижийг бүрдүүлэх үйл явцыг нэгээхэн хэсэг гэж тайлбарлаж болно.

Олон улсын радио нэвтрүүлэг нь соёлын солилцооны гол урсгал болдог төдийгүй нийт хүн төрөлхтний түүхийн хамгийн чухал эгзэгтэй,

ээдрээтэй мөчүүдийн тухай олон талын байр суурийг харуулсан мэдээлэл түгээдэг. Тухайлбал, дэлхийн II дайны явц, 1964 оны Карибын тэнгисийн хямрал, 1968 онд Варшавын гэрээний орнууд Чехословак улсад цэрэг оруулсан “Дунай” тусгай ажиллагаа, Британийн нэрт дуучин Жон Ленноны үхэл, Ливерпулийн дөрвөл “Битзл” хамтлагийн уран бүтээл, 1967 оны Араб-Изралийн зөрчил, ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхэлсэн тухай, Чернобылийн цөмийн цахилгаан станцад болсон дэлбэрэлт, Социалист системийн задрал, 1991 онд болсон Ирак-Кувейт-АНУ-ын хооронд өрнөсөн “Цөлийн шуурга” цэргийн ажиллагаа, Сянган ба Аомэнь БНХАУ-ын бүрэлдэхүүнд эргэн орсон тухай, 2001 оны 9 дүгээр сарын 1-нд Нью-Йорк хотод дэлхийн худалдааны төвийн ихэр цамхагт гарсан халдлага, Төв азийн орнуудад гарсан өнгөт хувьсгалууд, Арабын хавар хөдөлгөөн, Орос-Украины хямрал гээд олон үйл явдлын тухай цаг алдахгүй мэдээлж, хөндлөнгийн шинжээчдийн үзэл бодол, гадаадын улс орнуудын удирдагч нарын байр суурийг олон нийтэд хүргэж байсан түүхтэй. Олон улсын радио нэвтрүүлгийн үеэр хөндөгдсөн дээрх асуудлууд нь угсаа гарал ондоо янз бүрийн үндэстнүүдийн өөр зуураа ярилцах сэдэв болж, орчин үеийн нөхцөл байдлын задлан шинжилж, өөр өөрсдийн дүгнэлт хийх боломж олгодог. Энэ бол гадаадын сонсогчдод зориулсан тусгай нэвтрүүлгийн үзүүлж байгаа үр нөлөөний илрэл юм.

Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн салбарт интернэтийн сүлжээний нөлөө улам бүр нэмэгдэж байгаа нь олон улсын радио нэвтрүүлгийн хэлбэр, зохиомжид нөлөөлж,

мультимедиа шинжийг улам ихээр агуулах боллоо. Агаарын долгионоор л нэвтрүүлгээ дамжуулж сонсогчдод бүтээлээ хүргэдэг байсан олон улсын радио станцууд интернэтийн сүлжээнд вэбсайтаа нээж байна. Тухайлбал, “Америкийн дуу хоолой” радио станц 1994 онд интернэтийн сүлжээнд вэбсайтаа нээж, радио нэвтрүүлгээ хэсэгчлэн, эсвэл бүрэн эхээр нь гадаадын олон хэлээр сонсох хувилбарыг интернэт хэрэглэгчдэд санал болгож байлаа. Үүний дараа энэ жишгээр дэлхийн бусад улс орны радио станцууд вэбсайт нээх, ухаалаг гар утсаараа сонсох боломжтой App зохион бүтээж тасралтгүй хөгжүүлж байна. Ингэснээр олон улсын радио нэвтрүүлгийг сонсогч хүссэн үедээ сонсох, цаг үеийн шинжтэй мэдээллийг шуурхай хүлээн авах, олон улсын радио нэвтрүүлгийн хамт олонд цахим шуудан илгээх, шууд сэтгэгдлээ бичиж үлдээх байдлаар оролцож байр сууриа илэрхийлэх боломж нээгдсэн юм.

Эцэст нь дүгнэхэд олон улсын радио нэвтрүүлэг нь ХХ зууны 20-оод оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд өргөжин тэлж, аливаа улс орны гадаад бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд нь тусалж байгаа “зөөлөн хүч” болохын зэрэгцээ янз бүрийн улс үндэстнүүдийн соёлын харилцаа, мэдээлэл солилцооны гол эх үүсвэр болж чадсан байна. Дэлхийн бүх улс олон улсын радио өргөн нэвтрүүлэг эрхлэн явуулахдаа үндэсний эрх ашиг сонирхлын хүрээнд мэдээллийн бодлогоо боловсруулж орчин үеийн шинэ технологийг ашиглаж байна.

Эшлэл

1. Л.Норовсүрэн, Н.Ариунзаяа. 2010. Радио сэтгүүл зүй. Х. 45
 2. Н.А.Зыков. 2003. Внешнеполитическое вещание в условиях развития глобальных информационных процессов. Вестник Московского Университета. Серия Журналистика. №1. С.67
 3. Н.С. Барабаш. 2000. Радио журналистика. С. 406
 4. Создание «мягкой силы» Китая // Xinhua. URL: http://www.xinhuanet.com/politics/2013-12/31/c_118788013.html
- Ашигласан бүтээлийн жагсаалт**
1. Н.С.Барабаш. 2000. Радио журналистика. Москва.
 2. Н.А.Зыков. 2003. Внешнеполитическое вещание в условиях развития глобальных информационных процессов. Вестник Московского Университета. Серия Журналистика. №1.
 3. Л.Норовсүрэн, Н.Ариунзаяа. 2010. Радио сэтгүүл зүй. Улаанбаатар.
 4. Радио сэтгүүл зүй. “Сэтгүүлчийн номын сан” цуврал. 2020. Улаанбаатар.

Summary

The article provides a historical-genetic and comparative analysis of foreign broadcasting. In the chronotopic aspect the advanced experience of foreign countries (Germany, England, Russia, China, USA) is compared with the peculiarities of the formation of foreign broadcasting in Mongolia. The impact of new information communication technologies on the international broadcasting is researched. Based on the results of the study, the conclusion is made that at the first stage of its development, foreign broadcasting was not an instrument of foreign policy and rather contributed to the cultural enrichment and support of its compatriots in other countries.

Key words: radio broadcasting, mass media, propaganda, culture exchange, soft power, internet